



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 29 өдөр

Дугаар 676

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах,
үнийг шинэчлэн тогтоох, балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, түүний харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 8 нэрийн, нийт 341,838,166.00 (гурван зуун дөчин нэгэн сая найман зуун гучин найман мянга нэг зуун жаран зургаан) төгрөгийн балансын үнэ, 93,277,832.77 (ерэн гурван сая хоёр зуун далан долоон мянга найман зуун гучин хоёр төгрөг далан долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг 1 дүгээр хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, түүний харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 15 нэрийн, нийт 236,926,372.70 (хоёр зуун гучин зургаан сая есөн зуун хорин зургаан мянга гурван зуун далан хоёр төгрөг далан мөнгө) төгрөгийн балансын үнэ, 17,768,057.75 (арван долоон сая долоон зуун жаран найман мянга тавин долоон төгрөг далан таван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг 2 дугаар хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

3. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга О.Амарсанаа болон тогтоолд заасан байгууллагуудын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

3.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

31130002996

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн
6 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР, ТҮҮНИЙ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ,
ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ, БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ (автомашин)-ИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглал танд орсон он	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)				Шилжүүлэх байгууллагын нэр	Шилжүүлэн авах байгууллагын нэр	
							Цаашид ашиглах жил (хугацаа)	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ			
1	Ландкрузер-70, 76-15 ГАА	2021	122,900,000.00	122,900,000.00	-	122,900,000.00						Говь-Алтай аймаг дахь ШШГТ	
2	Ландкрузер-70, 06-06 ХОЕ	2021	122,900,000.00	122,900,000.00	-	122,900,000.00						Хорих ял эдлүүлэх алба	
3	Ландкрузер-105, 83-81 ӨВР	2014	85,008,166.00	85,008,166.00	85,008,166.00	-		3	1	42,504,083.00	42,504,083.00	Өвөрхангай аймаг дахь ШШГТ	439 дүгээр хаалттай хорих анги
4	Чиргүүл, 19-59 УЧ /Зил-130/	2015	1,000,000.00	1,000,000.00	1,000,000.00	-		1	1	500,000.00	500,000.00		
5	Бага оврын трактор	2015	5,000,000.00	5,000,000.00	3,583,333.62	1,416,666.38							
6	Өөрөө буулгагчтай чиргүүл	2015	1,450,000.00	1,450,000.00	1,039,166.38	410,833.62							Хэнтий аймаг дахь ШШГТ-419 дүгээр нээлттэй хорих анги
7	Мотоцикл	2016	1,650,000.00	1,650,000.00	1,650,000.00	-		1	1	200,000.00	200,000.00		
8	Мотоцикл	2020	1,930,000.00	1,930,000.00	997,166.77	932,833.23							
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН							341,838,166.00				43,204,083.00		

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн
676 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭГТЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР, ТҮҮНИЙ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ (тоног төхөөрөмж) ИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, төрөл	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)			Шилжүүлэн авах байгууллагын нэр
							Цаашид ашиглах жил (хугацаа)	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	
1	Зөөврийн дижитал рентген аппарат	1	186,834,322.70	186,834,322.70	9,341,716.14	177,492,606.56				429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг
	Дүн	1		186,834,322.70	9,341,716.14	177,492,606.56				
2	Дэлгэц /43 инч/	1	1,188,000.00	1,188,000.00	277,200.00	910,800.00				407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги
3	Машины станц /kelwood/	5	544,500.00	2,722,500.00	952,875.00	1,769,625.00				Хорих ял эдлүүлэх алба
4	Антен	1	187,000.00	187,000.00	143,000.00	44,000.00				
	Дүн	7		4,097,500.00	1,373,075.00	2,724,425.00				
5	Компьютер /Неүтбүүк/	10	2,342,035.00	23,420,350.00	-	23,420,350.00				Хууль зүй, дотоод хэргийн яам
6	1-р хоолны тогоо /100л/	1	2,790,000.00	2,790,000.00	-	2,790,000.00				
7	2-р хоолны тогоо /80л/	1	4,140,000.00	4,140,000.00	-	4,140,000.00				Төв аппарат
8	Жигнүүр	1	835,200.00	835,200.00	-	835,200.00				
9	Ухаалаг дэлгэц /65 инч/	1	8,800,000.00	8,800,000.00	2,933,333.40	5,866,666.60				
10	Зөөврийн хөл	1	1,100,000.00	1,100,000.00	366,666.60	733,333.40				Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба
	Дүн	15		41,085,550.00	3,300,000.00	37,785,550.00				

11	Мотор /Насос шугам, 5.5квт/	1	880,000.00	880,000.00	-	880,000.00				421 дүгээр нээлттэй хорих анги	Говь-Сүмбэр аймаг дахь ШШГГ-425 дугаар нээлттэй хорих анги
	Дүн	1		880,000.00	-	880,000.00					
12	Төрнежор	1	880,000.00	880,000.00	616,000.14	263,999.86					
13	Суурин дугуй	1	1,045,000.00	1,045,000.00	1,045,000.00	-	2	522,500.00	522,500.00	Шийдвэр гүйцэтгэх алба	401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг
14	Гүйлтийн зам	1	704,000.00	704,000.00	692,266.47	11,733.53			-		
15	Гүйлтийн зам	1	1,400,000.00	1,400,000.00	1,400,000.00	-	2	700,000.00	700,000.00		
	Дүн	4		4,029,000.00	3,753,266.61	275,733.39			1,222,500.00		
	Нийт хөрөнгийн дүн	28		236,926,372.70	17,768,057.75	219,158,314.95			1,222,500.00		